



# ТӨВ АЙМГИЙН ДЭЛГЭРХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

## 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### Аудитын тайлан

Төв аймгийн аудитын газрын дарга,  
Тэргүүлэх аудитор Л.Жаргалсайхан  
Утас: 70272582  
И-мэйл: jargalsaihan\_tuv@yahoo.com  
Факс: 70272582

Аудитын менежер: О.Амаржаргал  
Утас: 70273465  
И-мэйл: amaraa\_tuv@yahoo.com

Аудитор: Ж.Бямбацогт  
Утас: 70273463  
И-мэйл: j.beegii@gmail.com

Хавсралт 1: Агуулга  
Хавсралт 2: Аудитын гэрчилгээ  
Хавсралт 3: Менежментийн захидал  
Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан  
Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Аймгийн Аудитын газрын хаяг:  
Төв аймаг Зуунмод сум 6-р баг  
Төрийн байгууллагуудын 2-р ордон  
Цахим хуудас: tuv@audit.gov.mn

2017 оны 03 дугаар сар

## АГУУЛГА

---

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
8. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
9. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
10. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
11. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
12. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
13. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
14. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
15. Зөвлөмж
16. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

### **Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:**

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дүгээр зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын тамгын газрын төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд /ТӨВ-2017/128/СТА-ТШЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын тамгын газрын төсвийн 2016 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, программ хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын тамгын газрын 2016 оны төсвийн санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 01 дүгээр сарын 25-наас 2017 оны 03 дугаар сарын 25-ныг хүртэл хугацаанд хийхээр төлөвлөн Төв аймгийн Аудитын газрын санхүүгийн аудитын багийн гишүүн аудитор Ж.Бямбацогт хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын тамгын газрын 2016 оны төсвийн санхүүгийн тайланг 2017 оны 01 дугаар сарын 25-нд Төв аймгийн Аудитын газарт ирүүлсэн байна.

Төв аймгийн Аудитын газар аудитыг 2017 оны 1 дүгээр сарын 26-наас 2017 оны 3 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2017 оны 3 дугаар сарын 25-нд Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын тамгын газрын удирдлагад гардуулна.

### **Байгууллагын хууль, эрх зүйн орчин:**

Төсвийн захирагч нь Монгол улсын Төрийн албаны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээг худалдан авах тухай хууль, Төсвийн тухай хууль болон бусад хууль тогтоомжуудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

### **Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:**

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлд “харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр, төсөл зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах, Засаг даргаас бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь зохион байгуулалт, эрх зүй, аж ахуйн талаар болон Тамгын газрын хэлтэс, албадын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, нутгийн

захиргааны байгууллагыг чиглүүлэн удирдахад нь Засаг даргад туслах, Хурал, Засаг дарга, доод шатны нутгийн захиргааны байгууллагыг шаардлагатай мэдээллээр хангах, хууль тогтоомж, Засгийн газар, Хурал, Засаг даргын шийдвэрийг биелүүлэх үүрэг бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах, гүйцэтгэлд нь хяналт тавьж үр дүнг тооцох, тухайн шатны Хурлын хэвийн үйл ажиллагааг хангаж аж ахуйн талаар үйлчлэх” гэж энэ байгууллагын чиг үүргийг тодорхойлсон байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Төсвийн тухай Монгол улсын хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1.38 –д “төсвийн шууд захирагч” гэж төсвийн ерөнхийлөн захирагч болон төсвийн төвлөрүүлэн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг гэж заасны дагуу Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын тамгын газрын дарга төсвийн шууд захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Төсвийн шууд захирагчийн төсвийг Аймгийн ИТХ баталж сумын төрийн сангаас олгож байна.

Төсвийн захирагчийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

### **Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:**

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын тамгын газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой уламжлалт болон хяналтын эрсдэлийг илрүүлэх, үнэлэх үе шатны ажлын талаар товч толилуулья.

Аудитыг төлөвлөх үе шатанд байгууллага, түүний гадаад, дотоод орчны талаарх цуглуулсан мэдээлэл, ойлголтод үндэслэн эрсдэлийн үнэлгээний горим хэрэгжүүлэн 6 эрсдэлтэй асуудал тодорхойлон, тэдгээрийг ТАБ-СТА-Б-2.6 маягтад нэгтгэж, баримтжуулав.

Дээрх эрсдэлтэй асуудал тус бүрийг дахин нарийвчлан үнэлэхэд 1 асуудал эрсдэл өндөр, 3 асуудал эрсдэл дунд, 2 асуудал эрсдэл бага гэсэн үр дүн гарлаа.

Эрсдэлийн ерөнхий үнэлгээг ТАБ-СТА-В-4 маягтад нэгтгэн баримтжуулсан бөгөөд нийт эрсдэлийн үнэлгээний түвшин 36 байна.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн эрсдэл өндөр буюу зайлшгүй шалгах эрсдэлтэй 1 асуудлыг аудитын чиглэл тус бүрээр нэгтгэж, тэдгээрийг сорих, шалгах аудитын горим сорил, шалгуур үзүүлэлт, нотлох зүйл цуглуулах арга замыг холбогдох маягтаар баримтжуулан баталгаажуулсан болно.

### **Дотоод хяналт:**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын тамгын газрын төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзлээ.

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын тамгын газар санхүүгийн тайлан, тодруулга, төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэх, ажил гүйлгээг бүртгэх, хянах үйл ажиллагаанд санхүүгийн “Acolous” програм хангамж ашиглажээ.

### **Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:**

Батлагдсан төсвийг хуваарийн дагуу Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын тамгын газар 2016 онд 271,672.0 мянган төгрөгийн санхүүжилт авч урсгал зардалд 271,672.0 мянган төгрөг зарцуулсан байна.

### **Шилэн дансны мэдээлэл:**

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын тамгын газар нь 2016 оны 10 сард хийгдсэн Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгах нийцлийн аудитаар мэдээлбэл зохих мэдээлэлээс 5 мэдээлэл оруулаагүй байна.

### **Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:**

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 6 эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр хяналтын 5, нарийвчилсан 1, нийт 6 горим, сорил гүйцэтгэв.

Үр дагавар Эдгээр эрсдэлүүд нь төсвийг хэмнэлтгүй зарцуулсан, төсвийг үр ашиггүй зарцуулсан, төсвийн зориулалтыг зөрчсөн, хөрөнгийн хадгалалт хамгаалалтыг сулруулж цаашид хөрөнгийг үрэгдүүлэх, чанар байдлыг алдагдуулах, байгууллагын үйл ажиллагааны цар хүрээг бууруулсан, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхгүй зөрчдөг зэрэг муу үр дагаварт хүрч болзошгүй байна.

### **Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар:**

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын тамгын газрын 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцоолуудыг түүвэрчлэн нарийвчилсан сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/ Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт зардлын 84.7 хувийг эзэлж байна.

### **Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:**

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг хэмжээний 22,911.1 мянган төгрөгийн алдаа илэрсэн байна. Үүнд:

1. Мөнгөн гүйлгээний тайлангийн цэвэр мөнгөн гүйлгээний дүн 4410.0 мянган төгрөгөөр зөрүүтэй, данснаас хассан үндсэн хөрөнгийн дүнг 18501.1 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, тохиолдсон байх, үнэн зөв байх гэсэн батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Аудитын явцад залруулга хийсэн.

Материаллаг бус дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

2. Ахмадын холбооны даргын 635.0 мянган төгрөгийн урамшууллыг цалингийн сангаас олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41.2.2. батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн: Цалингийн санд зохицуулалт хийхгүй батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах тухай албан шаардлага өгөв

3. Зээлийн хүүгийн авлага дансанд 4155.8 мянган төгрөгийн сэлбэгийн материалын тооцоог бүртгэсэн нь НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, үнэн зөв байх гэсэн батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Сэлбэг хэрэгслийн материалын тооцоог хоблогдох авлага, өглөгийн дансанд бүртгэж байх зөвлөмж өгөв.

### **Материаллаг бүс залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:**

Аудитын явцад материаллаг 22,911.1 мянган төгрөгийн алдааг залруулсан болно.

### **Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:**

Тухайн аудитын хамрах хүрээний асуудал боловч аудитын хугацааны шалтгаанаас аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй байж болох асуудал байхгүй.

### **Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:**

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын тамгын газрын 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 27,701.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба үүнээс 635.0 мянган төгрөгийн албан шаардлага, 4155.8 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөгдлөө.

### **Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:**

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын тамгын газрын төсвийн 2015 оны санхүүгийн тайланд аудит хийж 2 зөвлөмж өгснийг хэрэгжүүлэн хариуг албан бичгээр Төв аймгийн Аудитын газарт ирүүлсэн байна.

### **Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт: Зөрчилгүй санал дүгнэлт**

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын тамгын газрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын

баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан 8 хуудас, байгууллагын санал 1 хуудсыг тус тус хавсаргав.

### АУДИТЫН ТАЙЛАНГ

#### ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Л.ЖАРГАЛСАЙХАН

АУДИТЫН МЕНЕЖЕР

О.АМАРЖАРГАЛ

#### БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

Ж.БЯМБАЦОГТ

Огноо: 2017.03.23